



# АЛТАН ГАДАС ОДОНТ “ХОРИНХОЁР ДУГААР БААЗ” ХК

2022 оны 03 сарын 21 өдөр

№ 22/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Г “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан 7  
хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.2.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлыг 2022.04.29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Энхтайвны өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр баталсугай:
  1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах.
  2. Компанийн 2021 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан З.Туяа танилцуулах.
  3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
  4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
  5. Компанийн Голomt банкны 121001656 тоот харилцах дансны гүйлгээ хийх эрхийг авах болон дансны бэлэн бус гүйлгээний эрхийг, Хаан банкинд данс нээлгэх болон цахим банкны үйлчилгээ авах болон бэлэн бус гүйлгээ хийх эрхийг тус тус гүйцэтгэх захиралд олгох.
  6. Компанийн мөнгө хөрөнгийг захиран зарцуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай.
  7. Дулааны шугам засвар, бохирын шугамын засвар болон дээврийн засвар хийх.
  8. Гарц гаргах тухай.
  9. Бусад.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04-р сарын 14-ний өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг  
8-р хороо, “22-р Бааз” ХК-ийн байр  
Утас: 976-11-452130  
Факс: 976-11-452415

